

БАТЛАВ: "БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТҮГ-ЫН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
...../Л.ЭНХБАТ/



"БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТҮГ

**СҮЛЖЭЭНИЙ ДЭД БҮТЦИЙН АШИГЛАЛТ, ГЭМТЭЛ ЗАСВАРЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалтын
нэр:

*Сүлжээний дэд бүтцийн ашиглалт, гэмтэл засварлах
үйлчилгээ үзүүлэх*

Тендер
шалгаруулалтын
дугаар:

БМТТ/20250201.....

2025 он 01 дүгээр сарын 13 өдөр

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
- 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид "үйлчилгээ" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**
- 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**
- 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**
- 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**
- 6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
- 6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

Б. АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.6-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг "тендерийн үнэ" гэж үзнэ.

21.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн

хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

- 31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
 - 32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
 - 32.1.2. ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
 - 32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
 - 32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
 - 32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
 - 32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
 - 32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
 - 32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер "хамгийн сайн" гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг

- үнэлсэн журмыг баримтална.
33. Тендерийг эрэмбэлэх 33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах 34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.
- 34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
- Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
35. Мэдэгдэл хүргүүлэх 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
36. Гүйцэтгэлийн баталгаа 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.
37. Урьдчилгаа төлбөр 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.
38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
39. Тендер шалгаруулалтын гомдол 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх

журам"-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Сүлжээний дэд бүтцийн ашиглалт, гэмтэл засварлах үйлчилгээ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <i>ДТМ/2025/0201</i>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: "Үгүй"
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөв
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 1,670,628,180 ₮ /нэг тэрбум зургаан зуун далан сая зургаан зуун хорин найман мянга нэг зуун наян төгрөг/
ТШЗ 7.1	Түншлэл: Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна. Туслан гүйцэтгүүлэх гэрээ, улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлнэ.
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Ж.Ариунболд Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, нарны зам, 87-р байр 6 давхар Цахим шуудангийн хаяг: www.tender.gov.mn Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд

	үзэхгүй." гэж заасны дагуу түншлэлээр тендерт оролцсон гэж үзэхгүй болохыг анхаарна уу.																		
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: "Шаардана"</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023, 2024 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</p>																		
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2022, 2023, 2024 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс татаж тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>																		
ТШЗ 18.4	Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч ирүүлнэ.																		
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: "Шаардана"</p> <ul style="list-style-type: none"> Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2022, 2023, 2024 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 35 хувиас багагүй үнийн дүнтэй Нийслэл болон 21 аймаг, сум, багт тоон суваг, /VPN/ үйлчилгээ, дэд бүтцийн засвар үйлчилгээ, Нийслэлд болон хөдөө орон нутагт өөрийн дата төв эсхүл үүнтэй дүйцэхүйц байр талбай, худаг сувагчлалаа түрээслүүлэн үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх. Гэрээний хуулбар, Хүлээлгэж өгсөн актын хуулбар эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт бичиг Тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. <p>Дээрх үйлчилгээнүүдийн явц нь 70 болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Захиалагчийн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд ижил төстэй ажлын туршлагад тооцно.</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: "Шаардана"</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэжлэ эрээ ажилласа н жилийн туршлага</th> <th>Мэргэжил</th> <th>Диплом ирүүлэх эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Байгууллага хариуцсан менежер</td> <td>Нийслэлд-1</td> <td>1 болон түүнээс дээш жил</td> <td>-</td> <td>Үгүй</td> </tr> <tr> <td>2</td> <td>Ерөнхий инженер</td> <td>Нийслэлд-1</td> <td>3 болон түүнээс дээш жил</td> <td>Сүлжээний инженер</td> <td>Үгүй</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлэ эрээ ажилласа н жилийн туршлага	Мэргэжил	Диплом ирүүлэх эсэх	1	Байгууллага хариуцсан менежер	Нийслэлд-1	1 болон түүнээс дээш жил	-	Үгүй	2	Ерөнхий инженер	Нийслэлд-1	3 болон түүнээс дээш жил	Сүлжээний инженер	Үгүй
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлэ эрээ ажилласа н жилийн туршлага	Мэргэжил	Диплом ирүүлэх эсэх														
1	Байгууллага хариуцсан менежер	Нийслэлд-1	1 болон түүнээс дээш жил	-	Үгүй														
2	Ерөнхий инженер	Нийслэлд-1	3 болон түүнээс дээш жил	Сүлжээний инженер	Үгүй														

3	Инженер	<ul style="list-style-type: none"> • Нийслэлд-2 • 21 аймгийн төв бүрд-1 • Багануур дүүрэгт-1 • Налайх дүүрэгт-1 • Багахангай дүүрэгт-1 	1 болон түүнээс дээш жил	Сүлжээний инженер	Үгүй
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	<ul style="list-style-type: none"> • Улсын хэмжээнд-5 	1 болон түүнээс дээш жил	ХАБЭА Сургалтад хамрагдсан хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх	ХАБЭА Сургалтад хамрагдсан хүчин төгөлдөр хугацаатай гэрчилгээтэй байх
5	Холбооны инженер	<ul style="list-style-type: none"> • Нийслэлд-5 • 21 аймгийн төв бүрд-1 • Багануур дүүрэгт-1 • Налайх дүүрэгт-1 • Багахангай дүүрэгт-1 	1 болон түүнээс дээш жил	Дамжуулахын инженер	Үгүй

- Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөл, арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.
- Дээрх инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсролын яамны мэдээллийн сангаас шалгана. "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө Боловсролын яамны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.
- Хэрэв гадаадын улс оронд боловсрол эзэмшсэн инженер техникийн ажилтнууд санал болгох бол тэдгээрийн дипломын эхээс хийсэн хуулбар, орчуулгын хамт ирүүлнэ.
- "Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>

- Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.
- Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна.
- Санал болгож буй ажилтнуудын жагсаалтыг V бүлгийн Маягт 7-ийн дагуу бөглөж ирүүлнэ.
- Дээрх инженер, техникийн ажилтнуудын 50-аас доошгүй хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай. /Нийслэлд санал болгосон ажилтнуудад хамаарна/
- Нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар буюу 2024 оны 10, 11, 12 дугаар саруудад тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан шалгах ба НД-8 маягтаар гаргасан тайланг хавсарган ирүүлэх шаардлагагүй.

Тендерт оролцогч нь орон нутаг дахь өөр байгууллагатай ажил гүйцэтгүүлэх гэрээтэй бол гэрээний хуулбарыг, тухайн байгууллагын инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэхийн хуулбарыг тод, гаргацтай ирүүлнэ.

Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: "Шаардана"

Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай дараах тоног төхөөрөмж, багаж, машин механизмуудыг зайлшгүй бэлэн байлгах тухай V бүлгийн Маягт 5-ийн дагуу бэлтгэн ирүүлнэ.

Сүлжээний дэд бүтцийн ашиглалт, гэмтэл засварлах үйлчилгээ үзүүлэгч нь дараах тоног төхөөрөмж, багаж, машин механизмуудыг зайлшгүй бэлэн байлгах хэрэгтэй. Доод тал нь нийслэлд-5, Багануур, Налайх дүүрэг, 21 аймгийн төв тус бүрд-1 ширхэг доорх тоног төхөөрөмжүүдийн иж бүрдэлтэй байна. Үүнд:

- Дамжуулах сүлжээ нь /L3 IP MPLS/ дэмждэг төхөөрөмжүүд, дэд бүтэцтэй байх.
- Console cable, Serial to USB шилжүүлэгч.
- Сүлжээний тестер.
- Сүлжээний кабелийн толгой хавчигч бахь.
- Шилэн кабелийн залгааны машины иж бүрдэл.
- Залгааны унтрал хэмжигч төхөөрөмж /OTDR, Multimeter/
- Шилэн кабелийн лазер /VFL/, дохио хэмжигч /Powermeter/
- Гэмтэл засварлахад хэрэглэх бэлэн материалын нөөцтэй байх /жампер кабел, конектор цэвэрлэгч, шилэн кабелийн муфт, FDF, adapter/
- Зөөврийн компьютер.
- Шилэн кабел татах болон суурилуулахад шаардлагатай тоног төхөөрөмжүүд.

	<p>Хөдөлмөр хамгааллын шаардлагад нийцэх ажлын иж бүрэн хувцас</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”</p> <p>Сүүлийн 3 жил буюу 2022, 2023, 2024 онуудад ижил төстэй үйлчилгээ гүйцэтгэсэн гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын дагуу бэлтгэн ирүүлнэ</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>V бүлгийн Маягт 4-ын дагуу бэлтгэн ирүүлнэ.</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ үзүүлэх хуваарийг нарийвчлан гаргаж баталгаажуулж ирүүлэх. • Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга Маягт 5-ын дагуу ирүүлэх. • Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал ТШЗ-д заасан дарааллаар дугаарлагд тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - <i>Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягт 7-ын дагуу ирүүлэх;</i> - <i>Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний мэдээллийг маягт №2-4-ийн дагуу</i> - <i>Үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</i> - <i>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллийг ирүүлэх, (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх);</i> - <i>Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.]</i> - <i>Тендерийн үнийн саналаа Маягт1-ийн дагуу баталгаажуулж ирүүлнэ.</i> - <i>2025 оны 3 дугаар сарын 1-нээс 2026 оны 2 дугаар сарын 28-ныг дуустал хугацаанд үйлчилгээ үзүүлэх хуваарийг баталгаажуулан ирүүлнэ./Төсөвт өртгийн хүрэн дэх төлбөрийн хуваарь 2025 оны 12 дугаар сарын 31-ныг дуустал хугацаанд хүчинтэй байна. 2026 оны 1, 2 дугаар сарын үйлчилгээний төлбөрийг 2026 оны төсөв батлагдсаны дараа гүйцэтгэлээр шийдвэрлэнэ./</i>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Уг ажлыг гүйцэтгэхэд эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр доорх тусгай зөвшөөрөл шаардлагатай.</p> <p>Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон</p>

	<ul style="list-style-type: none"> • “Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Улс хооронд/Транзит)”, “Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Улс хооронд)” <p>Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.</p>
ТШЗ 20.2	<p>Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</p> <p>Үйлчилгээ үзүүлэх даалгаврыг гүйцэтгэхтэй холбоотой шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хуудасны дугаар, харьцуулсан хүснэгт боловсруулж баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.</p>
ТШЗ 21.2	<p>Үнийн задаргааг баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно. III бүлэг, Техникийн тодорхойлолтын Маягт 13-ын дагуу ирүүлнэ.</p>
ТШЗ 21.5	<p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”</p>
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: Батлагдсан нийт төсөвт өртгийн 0,5% буюу 8,353,141₮ /найман сая гурван зуун тавин гурван мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг/.</p> <p>Хүчинтэй байх хугацаа: Тендерийн баталгаа нь гэрээ байгуулах хүртэл хугацаанд буюу 2025 оны 2 дугаар сарын 28-нийг дуустал хугацаанд хүчинтэй байна.</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Маягт №13-ын дагуу тендерт оролцогчоос ирүүлсэн үнийн дэлгэрэнгүй задаргаанаас бусад баримт бичиг.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2025 оны 02 сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 10:00 цаг</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p>

	<p>Огноо: Огноо: 2024 оны 02 сарын 13-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны зам 87-р байр 6-р давхарт, "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: "Үгүй"
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: "Тийм" Батлагдсан төсөвт өртгийн 3 хувьтай тэнцүү байна.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№ 1. Тоон сувгийн үйлчилгээний тодорхойлолт

1. Дараах хүснэгтэд дурдсан улсын хэмжээнд 350 байрлалд /нийслэл, аймаг, сум, баг/, 496 тоон сувгийн үйлчилгээ авна. Нэг тоон сувгийн үйлчилгээг олон сургууль хувааж ашиглаж болно. Дэд бүтэц хүрсэн цэг хүртэл тоон сувгийн үйлчилгээг авч, төгсгөлийн цэгээс ерөнхий боловсролын сургууль хүртэлх шилэн кабел нь захиалагчийн эзэмшил ба гүйцэтгэгч техникийн ашиглалт үйлчилгээг хариуцна.
2. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглалт, үйлчилгээ эрхлэх А ангиллын лицензтэй, 21 аймаг, 330 сумыг хамарсан байгууллага.
3. Тоон сувгийн үйлчилгээг эхлэлийн цэгээс төгсгөлийн цэг хүртэлх нийт дэд бүтэц дээгүүр хуваалцахгүйгээр /dedicated/, багасахгүйгээр дамжуулах зурвасын өргөн /bandwidth mbps/-ийг хангах.
4. Орон нутаг талдаа харилцан холболтын /ethernet/ 100/1000 Mbps интерфэйс холбох боломжтой байх.
5. Нийслэл талдаа харилцан холболтын /ethernet/ 2 x 10G Gbps оптик интерфэйс холбох боломжтой байх.
6. Шаардлагатай тохиолдолд VLAN tag бүхий логик холболт хийх боломжтой байх.
7. Гүйцэтгэгч өөрийн суурь сүлжээ болон бусад тоон сувгийн үйлчилгээ авагчдын сүлжээнээс захиалагчийн сүлжээг тусгаарлах зорилготой L2/L3 IP MPLS бүхий суурь дэд бүтэцтэй байх.
8. IPv4 OSPFv2, IPv6 түгээхтэй холбоотой OSPFv3 эсвэл IS-IS протоколоор харилцан холболт хийх боломжтой байх.
9. 24/7 Сүлжээний хяналт удирдлагын төвийн үйл ажиллагаатай байх бөгөөд нийслэл, орон нутгийн аль ч түвшинд асуудал гарвал нэн даруй шийдэх чадамжтай байх.

Тоон сувгийн үйлчилгээ авах цэгүүд:

№	Аймаг	Сум	Сургууль, сургуулийн байр	Байршил	Сүлжээ холболтын технологи	Bandwidth /Mbps/	Үйлчилгээ үзүүлэгч	Тасарсан хугацаа /цаг/
1.		Багануур	Оюуны эрин цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель	100	МХС	
			Боловсрол цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель			
			Гүн галуутай цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель			
2.	Улаанбаатар	Налайх	Хангай цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель	100	МХС	
			103-р сургууль /Чандмань цогцолбор/	Нийслэл	Шилэн кабель			
			109-р сургууль	Нийслэл	Шилэн кабель			
			119-р сургууль	Нийслэл	Шилэн кабель			
			Голомт цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель			
			Эрдмийн оргил цогцолбор сургууль	Нийслэл	Шилэн кабель			
			Эрдмийн оргил цогцолбор сургуулийн Тэрэлжийн бага сургууль	Нийслэл	Шилэн кабель			
3.		Сонгинохайрхан	160-р сургууль	Нийслэл	Шилэн кабель	1000	МХС	
			169-р сургууль	Нийслэл	Шилэн кабель			
4.		Баянзүрх	85-р сургууль	Нийслэл	Шилэн кабель	100	МЦХ	
			Ирээдүй цогцолбор сургууль	Аймгийн төв	Шилэн кабель			
5.	Архангай	Эрдэнэбулган	1-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	100	МХС	
			5-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель			
				Аймгийн төв	Шилэн кабель			

6.		3-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС
7.	Батцэнгэл	2-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС
8.	Булган	4-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС
9.	Жаргалант	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
10.	Их Тамир	Дунд сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
11.	Тариат	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
12.	Төвшрүүлэх	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	20	МХС
13.	Хайрхан	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
14.	Хангай	Дунд сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
15.	Хашаат	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
16.	Хотонт	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
17.	Хотонт сумын 6-р баг, Өндөр сант	Дунд сургууль	Баг	Шилэн кабель	10	МХС
18.	Цахир	Дунд сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
19.	Цэнхэр	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
20.	Цэцэрлэг	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
21.	Чулуут	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
22.	Өгийнуур	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	30	МХС
23.	Өлзийт	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
24.	Өндөр-Улаан	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
25.	Эрдэнэмандал	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС
	Баян-Өлгий	1-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	100	МХС

26.	10-р сургууль /Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор/	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
27.	9-р бага сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
28.	2-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
29.	3-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
30.	4-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
31.	5-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
32.	6-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
33.	7-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель	МХС
34.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС
35.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
36.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС
37.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
38.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
39.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС
40.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
41.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС
42.	2-р сургууль	Баг	Шилэн кабель	МХС
43.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
44.	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	МХС
45.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС
46.	Дунд сургууль	Баг	Шилэн кабель	МХС
47.	1-р сургууль	Сум	Шилэн кабель	МХС

37.

38.

39.

40.

41.

42.

43.

44.

45.

46.

47.

48.

49.

50.

Толбо	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС	
Улаанхус	1-р сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС	
Цэнгэл	2-р сургууль	Сум	Шилэн кабель	10	МХС	
	1-р сургууль	Сум	Шилэн кабель		МХС	
	Соого Сейкео сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	5-р сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
Баянхонгор	Гэгээн сумади / 6-р сургууль /	Аймгийн төв	Шилэн кабель	100	МХС	
	Эрдэм сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	Сургууль цэцэрлэгийн цогцолбор	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	Номун далай цогцолбор сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	Эрдэнэмандал сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	Номгон сургууль	Аймгийн төв	Шилэн кабель		МХС	
	Ахлах сургууль	Сум	Шилэн кабель		10	МХС
	Дунд сургууль	Сум	Шилэн кабель			МХС
	Дунд сургууль	Сум	Шилэн кабель			МХС
